



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 399

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчид байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй 21 нэрийн, нийт 317,984,502.47 (гурван зуун арван долоон сая есөн зуун наян дөрвөн мянга таван зуун хоёр төгрөг дөчин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автотээврийн хэрэгслийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор, Онцгой байдлын ерөнхий газрын дарга хошууч генерал Г.Ариунбуян болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэг материал болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4.Акталж, сэлбэгээр худалдсан автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001077
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
399 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИД БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Автомашины нэр, марк,	Улсын дугаар	Балансын нийт үнэ /Хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	ТӨБЗГ-ын бүүлд худалдахаар гарсан тогтоолын дугаар
1	Ховд аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв	Ланд-80	00-46 ХОУ	16,181,818.00	2023-516
2	МУИС, (Завхан сургууль)	Хьюндай старекс	18-88 ЗАН	15,500,000.00	2023-602
3	МУИС (Дорнод сургууль)	Хьюндай старекс	69-65 ДОР	10,000,000.00	2023-602
4	Өвөрхангай аймгийн ХХААГ	трактор пад		1,910,000.00	2023-398
5	Өвөрхангай аймгийн ХХААГ	трактор ЮМЗ		4,857,165.00	2023-398
6	Замын-Үүд дахь ШШГХ	Фургон-УАЗ	89-67 ДГО	31,659,574.47	2023-450
7	Замын-Үүд дахь ШШГХ	Жийп Хятад	87-88 ДГО	18,975,000.00	2023-450
8	ШШГГ харьяа Үйлдвэр аж ахуй барилгын хэлтэс	Хьюндай грейс	90-53 УНП	8,000,000.00	2023-450
9	ШШГГ харьяа Үйлдвэр аж ахуй барилгын хэлтэс	Маяти крантай	16-84 УНА	10,600,000.00	2023-450
10	Багануур ШШГХэсэг	Киа серано	02-17УНУ	33,000,000.00	2023-450
11	ШШГГ харьяа ШТН	Пад трактор		1,400,000.00	2023-450
12	433 дугаар хаалттай хорих анги	Фургон	04-33 СБА	31,000,000.00	2023-582
13	413 дугаар нээлттэй хаалттай хорих анги	Трактор /бага оврын/		5,000,000.00	2023-818
14	413 дугаар нээлттэй хаалттай хорих анги	Исузу вигхорн	27-56 СЭН	29,925,000.00	2023-818
15	413 дугаар нээлттэй хаалттай хорих анги	Капатель төмс		7,700,000.00	2023-818
16	Дорнод аймаг дахь ШШГГ	Карнивал	05-50 ДОУ	35,000,000.00	2023-818
17	413 дугаар нээлттэй хаалттай хорих анги	Зил-130	59-25 СБА	3,978,875.00	2023-818
18	413 дугаар нээлттэй хаалттай хорих анги	Пронтер	49-42 СЭА	8,500,000.00	2023-818
19	Багануур дүүрэг дэх ШШГХ	Киа серато	04-37 УБУ	33,000,000.00	2024-99
20	(Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар)	ГАЗ-66 автомашин	24-71 ГСА	3,297,070.00	2024-273
21	409 дүгээр хаалттай хорих анги	Маяти	57-41 УБП	8,500,000.00	2024-489
Нийт дүн				317,984,502.47	
				(гурван зуун арван долоон сая есөн зуун наян дөрвөн мянга таван зуун хоёр төгрөг дөчин долоон мөнгө)	